

БАРИЛГЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа, шинээр барьсан, өргөтгөл шинэчлэл хийсэн барилгын эрчим хүчний үр ашгийг баталгаажуулах, гэрчилгээ олгохтой холбогдон үүсэх аливаа харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэ журмын зорилго нь барилга байгууламжид хүн ажиллах, амьдрах орчны бичил уур амьсгалын нөхцөлийг хангахад шаардагдах эрчим хүчний хэрэглээний үзүүлэлтийг тодорхойлон, гэрчилгээжүүлэх замаар барилгын насжилтыг уртасгах, ашиглалтын хугацааны зардлыг бууруулах, эрчим хүч хэмнэх суурь нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

1.3. Барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох үйл ажиллагаанд Барилгын тухай хууль, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Барилгын дулаан хамгаалалтын холбогдох норм, норматив баримт бичгийг удирдлага болгоно.

Хоёр. Барилгын эрчим хүчний гэрчилгээ

2.1. Барилгын эрчим хүчний гэрчилгээг барилгын дулаан хамгаалалтын холбогдох норм, норматив баримт бичгийг үндэслэн боловсруулах ба гэрчилгээний загвар, хэлбэр хэмжээ, өнгөний кодыг энэ журмын хавсралтаар тодорхойлно.

2.2. Зураг төсөл боловсруулах шатанд барилгын эрчим хүчний гэрчилгээг заавал авах ба уг үйл ажиллагааг Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

2.3. Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 3.1.8 заасан иргэн, аж ахуйн нэгж байгууллага болон бусад ашиглагдаж байгаа барилгад эрчим хүчний гэрчилгээ олгох үйл ажиллагааг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл зохион байгуулна.

2.4. Барилгын эрчим хүчний гэрчилгээг хугацаатай олгох ба зураг төслийн шатанд авах гэрчилгээ нь Барилгын тухай хуулийн 14.6-д заасан хугацаанаас, ашиглагдаж байгаа барилгад авах гэрчилгээ нь Барилгын тухай хуулийн 46.1.14-т заасан хугацаанаас тус тус хэтрэхгүй байна.

Гурав. Гэрчилгээ олгох үйл ажиллагаа

3.1. Энэ журмын 2.2-т заасан барилгын эрчим хүчний гэрчилгээг дараах баримт бичгийг үндэслэн олгоно:

3.1.1. захиалагчийн албан хүсэлт;

3.1.2. холбогдох норм, норматив баримт бичгийн дагуу тооцсон барилгын эрчим хүчний үндсэн үзүүлэлт;

3.1.3. барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийсэн дүгнэлт */Халаалт, агаар сэлгэлтийн магадлал хийгчийн дүгнэлт/*.

3.2. Энэ журмын 2.3-т заасан барилгын эрчим хүчний гэрчилгээг дараах баримт бичгийг үндэслэн олгоно:

3.2.1. барилгын өмчлөгч, эзэмшигчийн албан хүсэлт;

3.2.2. холбогдох норм, норматив баримт бичгийн дагуу тооцсон барилгын эрчим хүчний үндсэн үзүүлэлтийг тодорхойлсон эрчим хүчний аудитын баталгаат дүгнэлт;

3.2.3. барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан нь эрх бүхий байгууллагаар баталгаажсан улсын комиссын дүгнэлт.

3.3. Барилгын эрчим хүчний гэрчилгээ олгогч бүрдүүлбэрийн үнэн бодит байдлыг тодруулах тодруулах зорилгоор нэмэлт мэдээлэл, лавлагаа авах, барилга байгууламжид хэмжилт хийх ажлыг зохион байгуулж болно.

3.4. Энэ журмын 3.1, 3.2-т заасан баримт бичгийн бүрдүүлбэр нь шаардлага хангасан бол барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох асуудлыг хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 10 хоногт багтаан шийдвэрлэнэ.

3.5. Энэ журмын 3.3-т заасан нөхцөл байдал үүсвэл гэрчилгээ олгох хугацааг нэг удаа ажлын 10 хоногоор сунгаж болно.

3.6. Барилгын эрчим хүчний гэрчилгээг хаяж үрэгдүүлсэн бол энэ журмын 3.1, 3.2-т заасан баримт бичгийг дахин бүрдүүлж, шинээр авна.

3.7. Гэрчилгээ бүхий барилга байгууламжийг бүртгэлжүүлэх, мэдээллийн сан үүсгэж, цахимд ил тод байршуулах ажлыг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл хариуцна.

3.8. Гэрчилгээ олгох үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор цахим системийг ашиглаж болно.

Дөрөв. Барилгын эрчим хүчний гэрчилгээ эзэмшигчийн эрх, үүрэг

3.1. Барилгын эрчим хүчний гэрчилгээ олгоход шаардлагатай мэдээллийг үнэн зөв гаргаж өгөх.

3.2. Энэ журмын 2.2-т заасан гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хүчинтэй хугацаанд багтаж энэ журмын 2.3-т заасан гэрчилгээг авах.

3.3. Барилгыг шинэчлэх, өргөтгөх, их засвар хийх зэргээр эрчим хүчний хэрэглээнд өөрчлөлт орсон, гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд эрчим хүчний аудит хийлгэн барилгын эрчим хүчний гэрчилгээг шинээр авах.

3.4. Гэрчилгээ авахтай холбогдон гарах зардал, санхүүжилтийг хариуцах.

3.5. Барилгын эрчим хүчний гэрчилгээний үзүүлэлтийг дээшлүүлэх арга хэмжээг авах.

3.6. Барилгын эрчим хүчний гэрчилгээг үйлчлүүлэгч, хэрэглэгчийн нүдэнд ил харагдах газар байрлуулах, сурталчлах.

Дөрөв. Бусад

4.1. Барилгын эрчим хүчний гэрчилгээг өмчлөгч, эзэмшигчид хоёр эх хувь олгож, хуулбар хувийг баримт бичгийн бүрдлийн хамт архивлана.

4.2. Гэрчилгээ олгохтой холбогдон үүсэх аливаа санал, хүсэлт, гомдлыг гэрчилгээ олгогч байгууллага харьяаллын дагуу хүлээн авч холбогдох арга хэмжээ авч шийдвэрлэнэ.

4.3. Барилгын эрчим хүчний үзүүлэлтийг тодорхойлох мэргэжлийн /эрчим хүчний аудитын, магадлал хийгч/ дүгнэлтийг чанаргүй эсхүл буруу гүйцэтгэснээс үүсэх үр дагавар, зардлыг мэргэжлийн дүгнэлт гаргасан эрх бүхий этгээд хариуцна.